

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн
үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын
сангаас олгох хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль/шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар
зүйлийн 35.9.8 дах заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол,
мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль/шинэчилсэн
найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн
үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох
хэмжээг нэг ор хоногт 70 000 (далан мянга) төгрөгөөр тогтоосугай.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, үйлдвэрлэлийн осол,
мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас сувилалын газарт олгож байгаа
санхүүжилт, үйлчилгээний чанарт тогтмол хяналт тавьж ажиллахыг Нийгмийн
даатгалын ерөнхий газарт үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын
үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 16 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын
01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж
мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ